


A circular botanical illustration border surrounds the central text. It features various plants including ferns, a red maple leaf, a green leaf with a white vein, a yellow flower, a green leaf with a white vein, a red leaf, a purple flower, and a green leaf with a white vein.

# МОНГОЛ ГЭРТЭЙ ХОЛБООТОЙ ЗАН ҮЙЛ, ЦЭЭР, БЭЛГЭДЭЛ

---

[D.Urantsetseg@must.edu.mn](mailto:D.Urantsetseg@must.edu.mn)

# Гэрийн бүтэц



# Монгол гэртэй холбоотой зан үйл



- Монголчууд гэрийнхээ хаалгыг наран ургах зүгт харуулж барьдаг нь гэрийн тооноор тусах нарны гэрлээр цаг мөч мэддэгтэй холбоотой юм.
- Гэрийн тавилгуудаас авдар сав гэх мэт том зүйлсээс бусдыг нь гэр барих буурин дотроо тавиад хатавчны баруун зүүн ханаа уядаг.

Гэрийн ханыг гэрийн бууринд дугуйлж хана тус бүрээ хооронд нь нийлүүлэн боох ба "нохой ам"-аар нийлүүлэхийг хориглоно.

Гэрийн хаалгыг уулын онь чиглүүлэхийг цээрлэнэ. Гэрийн хаалгыг хазгай муруйгүй тэгш барихыг ямагт эрхэмлэнэ.



## Монгол гэртэй холбоотой цээрлэх ёс




# Монгол гэртэй холбоотой бэлгэдэл



Гэрийн доторх зайг хоймор тал, үүдэн тал, гэрийн эзэгтэйн тал, гэрийн эзний тал гэж ялгах нь гэрийн дотор баримтлах ёс ба зай талбайн журмыг тогтоосон хэв ёс байжээ. Монголчууд гэрийнхээ гол дунд гал голомт тулгаа байрлуулдаг. Түүнийг тойрсон орон зайн баруун тал нь эрэгтэй хүний эд зүйл, зүүн талд эмэгтэй хүний эд зүйлийг байрлуулдагаас уламжлан эзэгтэй тал, эрэгтэй хүний тал хэмээх болсон. Гэрийн доторх орон зайг 12 жилээр хуваан нэрлэх, зүг чиг заах, өнгөөр ялган гэрийн наран цагийн хуваарийг бий болгосон нь гэртэй холбоотой ардын мэдлэгийн нэгэн өв байв.

- Айл нохойгоо хорихгүй, гэрээс хүн гарч угтаагүй бол орохгүй.
- Айлд эд юм, бэлэг хүргэж яваа хүн доод талдаа тавихыг цээрлэнэ.
- Айлд өвдгөө салаавчлах, хөлөө ачиж суухыг цээрлэнэ.
- Айлд нөмгөн (бүсээ бүслээгүй) орохыг цээрлэнэ.
- Айлчилж хонох хүн ор дэвсгэр засаж өгөөгүй байхад бүхлээр буюу хувцсаа тайчин хэвтэхийг цээрлэнэ. Зөрчвөөс ёс алдана, жудаггүй гэгдэнэ.
- Айлын тулга, зуухыг өшиглөхийг цээрлэнэ.



## Цээрлэх ёсон



# Цээрлэх ёсон



- Галд сүү тусаахыг цээрлэнэ. Үнээ малын хөх гэмтэнэ, сүү татрана гэж үздэг.
- Гэр барьж байгаатай таараад унь өлгөлцөлгүй, дээвэр тавихад туслалгүй явахыг цээрлэнэ. Учир нь айл гэрийг хүндэлсэнгүй, эв эе эвдэрсэний шинж.
- Давс гуйхад харамлавал цавь нь цоорхой, эвэрхийтэй хүүхэд гарна.
- Дал идэхдээ шүд амаараа зулгаахыг цээрлэнэ. Заавал хутга хэрэглэнэ. Нагацын талд муу юм тохионо гэдэг.
- Дуутай бороо орох үед айраг бүлэхийг цээрлэнэ. Аянга бууна.
- Дээл, малгай хувцасан дээгүүр алхаж гарахыг цээрлэнэ. Эзэн дээгүүр нь гарсантай адил гэж үзнэ.





## Дасгал-3

Сурах бичиг-144 хуудас

